

**Зонховын “Их бодь мөрийн зэрэг”-ийн хоёр зүйл дадол буюу
дохионы тайлбарын тухай**

Доржсүрэнгийн БҮРНЭЭ*
Монгол улс, Улаанбаатар,
Монгол Улсын Их Сургууль,
Шинжлэх Ухааны Сургууль,
Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим

Received: Jun 25, 2025 | **Revised:** Oct 08, 2025 | **Accepted:** Dec 16, 2025

Хураангуй: Богд Зонховын (1357-1419) зохиосон “Их бодь мөрийн зэрэг” (тө. བླ་མཁུ་ལམ་རིམ་ཚེན་མོ།, 1402) бол буддын шашны гэгээрэлд хүрэх зам мөрийг гурван төрөлхтний замналаар тогтолцоотой өгүүлсэн шашин гүн ухааны алдартай сурвалж бичиг билээ. Тус бүтээлийн судлалтай холбоотой хөтөлбөр, тайлбар, үндэс дамжлага, оюун судалбар, уншлага, залбирал, шүлэг дуулал, сургаал, магтаал зэрэг олон бүтээл төвөд хэлээр уламжилж иржээ. Тэдгээрийн нэг бол “дохионы тайлбар” буюу дадол (тө. *brda bkrol*) юм. Дадолд нэр томъёо, оноосон нэр, санскрит үг, хуучирсан хэллэг, нутгийн аялгуу, хэлц хэллэг тэргүүтнээс түүвэрлэн тухайн зохиолд орсон дарааллаар тайлбарласан байдаг. Тус өгүүлэлд Ажа ёнзин Янжингавилодой (1740-1827) болон Балман Гончигжалцан (1764-1853) нарын бичсэн дадолыг харьцуулна.

Ажа ёнзин Янжингавилодой 650 гаруй үг хэллэгийг олон сурвалж бичиг, аман мэдээ ашиглаж дэлгэрэнгүй тайлбарлажээ. Балман бандида Гончигжалцангийнх хураангуй, 150 гаруй үг хэллэгийг хамарч байна.

Энэхүү хоёр бүтээл нь “Их бодь мөрийн зэрэг”-ийг уншиж судлах, орчуулах төдийгүй толь зүйч нарт чухал хэрэглэгдэхүүн, гарын авлага болсоор ирсэн байна.

Түлхүүр үг: “Их бодь мөрийн зэрэг” дадол, Ажа ёнзин Янжингавилодойн дадол, Балман Гончигжалцангийн дадол

Two Lexical Interpretations (*brda bkrol*) on the *Lam rim chen mo*

BURNEE Dorjsuren
Department of Mongolian Language and Linguistics
School of Art and Sciences, National University of Mongolia,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: The བླ་མཁུ་ལམ་རིམ་ཚེན་མོ།, or *The Great Treatise on the Stages of the Path to Enlightenment* (composed in 1402 by Tsong kha pa [1357–1419]), is one of the most influential

* © Д.Бүрнээ 2025
Email: burneedorjsuren@gmail.com

religious and philosophical works in Tibetan Buddhism. It systematically presents the path to enlightenment of the beings of the three capacities. A vast corpus of literature—encompassing instructions, commentaries, manuals, invocations, recitations, prayers, poems, hymns, aphorisms, and praises—has emerged around this seminal text, primarily transmitted in the Tibetan language. Among these, particular significance is attached to the genre known as *brda bkrol* (pronounced *da dol* in Mongolian), or "word interpretation." This article examines *brda bkrol* of *A kya yongs 'dzin dbyangs can dga' ba 'i blo gros* (ཨ་ཧྲུ་ཡོངས་འདིན་དབྱངས་ཅན་དགའ་བའི་སློ་བློ་ལྷན་པའི་མཛན་པོ།, 1740–1827) and *dpal mang paN+dita dkon mchog rgyal mtshan* (དཔལ་མང་པ་སྤྲིན་དཀོན་མཚོ་གཏུ་མཚན་པོ། (1764–1853).

A kya yongs 'dzin dbyangs can dga' ba 'i blo gros's work provides detailed explanations for over 650 terms and phrases, drawing from a wide range of canonical sources and oral traditions. In contrast, dpal mang paN+dita dkon mchog rgyal mtshan's work, while more concise, offers interpretations of over 150 key terms, making it an accessible yet valuable contribution to the field.

These two commentaries focuses on clarifying and interpreting terms and expressions used in the Lam rim chen mo, serving as a vital tool for readers, scholars, translators, and dictionary compilers.

Key words: *The Great Treatise on the Stages of the Path to Enlightenment, word explanation, A kya yongs 'dzin dbyangs can dga' ba 'i blo gros's explanation, dpal paN+dita dkon mchog rgyal mtshan's explanation*

1. Удиртгал

2000 гаруй жилийн тэртээгээс бурхан Буддагийн зарлиг сургаалыг зааж сургах, сурах зорилгоор тайлбар бичиж ирсэн эртний уламжлалтай бөгөөд энэ уламжлал буддын шашинт улс орнуудад хөгжин дэлгэрсэн түүхтэй. Энэхүү тайлбар зохиолууд нь буддын шашны үзэл онолыг хэлбэр агуулгын тухайд бүрэн дүүрэн уламжлан хадгалах, эмхэтгэх, хөгжүүлэх зорилгод чиглэж байв. Төвөд хэлээрх тайлбар зохиол нь:

1. Үндсэн зохиолын (тө. ལྷན་པོ།) утга санааг тодорхой жишээ баримтаар баяжуулж, дэлгэрүүлж бичсэн байдаг. Жишээ нь: “Субашид”, “Бодисадвын явдалд орохуй”-н тайлбарыг дурдаж болно. Тайлбар зохиол нь “үндсэн зохиол”-ыг үргэлжилсэн үгээр тайлбарласан бие даасан зохиолын шинжтэй.

2. Шашин гүн ухаан, тодорхой нэг эрдэм ухааны чиглэлээр бичсэн эх зохиолын агуулгыг задалж тайлбарлана.

3. Үгсийн сан болон хэлний зүйн холбоотой тайлбар бас буй.

“Ижил үгүй Богд Зонховын зохиосон их бодь мөрийн зэрэг” (*mnyam med tsong kha pa chen pos mdzad pa'i byang chub lam rim che ba bzugs so*) [Их бодь мөрийн зэрэг] бүтээл бол их бага хөлгөний сурвалж бичгүүдийг үндэс суурь болгож, гэгээрэлд хүрэх зам мөрийг нарийн дэс дараалалтай гүн гүнзгий өгүүлсэн зохиол юм.

“Их бодь мөрийн зэрэг”-ийг анх 1402 зохиогдсон үеэс хойш түүний гүн гүнзгий утга агуулгыг тайлж унших зорилгоор олон үеийн мэргэд тайлбар зохиож байв.

Ихэнхдээ буддын шашин гүн ухааны алдартай бүтээлүүдэд тайлбар бичих энэтхэгийн уламжлал Төвөдөд эрт цагаас дэлгэрсэн байна.

Тайлбар зохиол бол төвөд утга зохиолын нэг бие даасан төрөл зүйл болж хөгжсөн бөгөөд “Их бодь мөрийн зэрэг”-ийн дөрвөн зүйлийн тайлбар уламжилж иржээ. Үүнд:

1. Басо Чойжижанцаны (1402-1473) 15 дугаар зууны тайлбар, “мар чан” (тө. དམར་མཚན, мо. улаан хадмал) гэж нэрлэж заншсан. Улаан гэсэн нь улаан шунхаар бичсэнээс үүдэлтэй.
2. Даглун брагва Лодойжамцын (1606-1679) 17 дугаар зууны тайлбар, “наг чан” (тө. ནག་མཚན, мо. хар тайлбар) гэж алдаршсан, хар бэхээр бичсэнээс тийнхүү нэрлэжээ.
3. Жамъяншадав Агваанзундуйн (1648-1722) тайлбар, བྱང་ཚུབ་ལམ་གྱི་རིམ་བཞི་མཚན་འབྲེལ་གསེར་གྱི་འཁོར་ལོ་ нэртэй, товч нэрээр “сэр чан” (тө. སེར་མཚན, мо. шар тайлбар), алт хольж бичсэн учраас тийнхүү нэрлэжээ (Dkon mchog rgyal mtshan, х. 7а).
4. Бради гэвш Ринчиндондовын (17 зуун) тайлбар

Эдгээр дөрвөн тайлбарыг “Ижил үгүй богд Зонхов бээр зохиосон их бодь мөрийн зэргийн бэрх оньс нугуудыг дөрвөн хадмалын үүднээс сайтар номлосон их хөлгөний мөрийн гийгүүлэгч зул”, товч нэрээр “Мөрийн зэргийн дөрвөн хавсарсан тайлбар” (ལམ་རིམ་མཚན་བཞི་སྒྲག་མ།) гэдэг. Тус тайлбарыг 1802 онд анх барлаж, 1842 онд дахин хянан засварлаж хэвлэсэн байна. Тус бүтээлд тайлбар зохиогчдын нэрийг товчилж тэмдэглэжээ. Үүнд: Жамъяншадавын нэрийг Жа (тө. ཅ), Харог ханчэн Агваанравданг На (тө. ང), Басо Чойжижанцанг Ба (тө. བ) гэж тайлбарын дээд талд тавьснаас хэний тайлбар болохыг харж болно. Тус хадмал тайлбар төвөд “Их бодь мөрийн зэрэг”-ийг уншиж судлах, орчуулах хүмүүст чухал гарын авлага болж ирсэн байна.

Энэ хадмал тайлбараас гадна уншигч, орчуулагчдын “Их бодь мөрийн зэрэг”-ийг унших, судлахад зориулж, тухайн зохиолын зарим үгсийг түүвэрлэн тайлбар бичиж ирсэн нь дохионы тайлбар (тө. བརྗེ་བཞེས) нэртэй. Төвөд, монгол утга зохиолын уламжлалаас харвал нэрд гарсан зохиолоос маргаантай үг хэллэгийг түүвэрлэн тайлбарласан дадол хэмээх нэг зүйлийн тайлбар цөөнгүй байдаг. Монгол уламжлалт толь бичигт энэ төрөл зүйл уламжилсан тухай Ц.Шагдарсүрэн дурджээ (2008: 37). Дадол бол түүвэр нэрс буюу дүйминтэй (тө. btus ming) төстэй. Дүйминд түүвэрлэсэн үгсийг зонхилон монгол хэлнээ төвөд үсгээр үгчлэн буулгаж орчуулдаг бол дадолд зонхилон тайлбарладаг. Төвөд, монгол толь зүйчид толь бичиг найруулахдаа дадолыг өргөн ашиглаж байжээ.

Энэхүү өгүүлэлд Ажа ёнзин Янжингавилодой, Балман бандида Гончигжалцан нарын “Их бодь мөрийн зэрэг”-ийн дадолыг авч үзнэ. Үүнд: Тус хоёр бүтээлийг судалсан байдал, онцлог болон төвөд, монгол толь зүйчдийн бүтээлд хэрхэн уламжлагдсан асуудлыг хөндөнө.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Төвөд утга зохиолд дадол хэмээх нэг зүйл үгсийн тайлбар бүхий зохиолын төрөл зүйл уламжилж ирсэн байна. Тайлбар зохиолоос ялгаатай нь тухайн эх зохиолоос зөвхөн

маргаантай үг хэллэгийг түүвэрлэж тайлбарлажээ. Энэхүү өгүүлэлд хоёр зүйл дадолыг харьцуулах аргаар судлав. Үүнд:

1. Ажа ёнзин Янжингавилодойн (1740-1827) бичсэн бүтээл “Их бодь мөрийн зэргийн зарим чухал хэрэглэгдэх дохионы тайллын хураангуй” (བྱང་ཚུབ་ལམ་གྱི་རིན་པོ་ཆེན་པོ་ལས་བྱུང་བའི་བཅོམ་པོ་ལོ་བཟོ་བ་སྐྱོད་པ།) нэртэй. Бар болон гар бичмэлээр тааралдана. Ц.Дамдинсүрэнгийн гэр музейд 63 нүүр гар бичмэл судар хадгалагдаж байна. Бүртгэлийн дугаар №999.ТН-1089 (ХШ) (Мөнх-Отгон, 2018: 611).
2. Балман Гончигжалцангийн (1764-1853) зохиосон “Их бодь мөрийн зэргийн дохионы тайлал оршвой” (ལམ་རིམ་ཆེན་མོའི་བཅོམ་པོ་ལོ་བཟོ་བ་སྐྱོད་པ།). Тус тайлбар 14 нүүр, манай улсын ҮНС-д хадгалагдаж байна. Гончигжалцан бол Лавран хийдийн 24 дэх ширээт лам байсан бөгөөд, 11 боть зохиолтой, зохиолын Да (da) буюу 11 дүгээр ботид “Их бодь мөрийн зэргийн дохионы тайлал” оржээ.

Түүнчлэн дээрх хоёр дадолын үндсэн хэрэглэгдэхүүн болох Зонховын “Их бодь мөрийн зэрэг”, “Мөрийн зэргийн дөрвөн хавсарсан тайлбар” (ལམ་རིམ་མཚན་བཞི་སྟེན་མ།) [чандэл], Сумадираднаагийн 1877 онд бичсэн “Харанхуйг арилгах зул” тэргүүтэй төвөд-монгол дохионы бичгүүд, холбогдох судалгааг ашиглав.

3. Судалгааны хэсэг

3.1. Ажа ёнзин Янжингавилодойн дадолын тухай

Ажа ёнзин Лувсандондов буюу Янжингавилодой (1740-1827) [Янжингавилодой] бол Төвөдийн Гүмбүм хийдийн 40 дүгээр ширээт Лувсанжамъянжамцын (1768-1816) ёнзин (тө. yongs 'dzin) буюу багш учраас Ажа ёнзин гэж алдаршжээ. Янжингавилодойн бүтээлийн талаар Ц.Дамдинсүрэн дурдахдаа: “Мэргэн тэнэгийг шинжих цагаан лянхуа” нэрт банчин Содномдагвын сургаалын шүлэгт “Нарны гэрэл” гэдэг тайлбар бичсэн, “Үлгэрийн ном эрдэнэ цогцолсон”, “Хөх товхимол”-ын дадолыг бичсэн, хоёр боть сүмбүмтэй, 1809-1830 оны хооронд уран зохиол, яруу найргийн онолоор багагүй зүйл хийсэн, нэрээ хэдэн янз бичдэг гэж тэмдэглэжээ (Монголын уран зохиолын тойм, 1977: 564-565). Янжингавилодойн бичсэн дадол бүтцийн тухайд дэлгэрэнгүй мөргөлийн үг болон оршилтой, тайлбарлахаар сонгосон толгой үгсийг “Их бодь мөрийн зэрэг”-ийн бүлгийн үндсэн дарааллаар тэмдэглэж тайлбарласан бөгөөд төгсгөлийн үгтэй. Толгой үгсийг Зонховын “Их бодь мөрийн зэрэг”-ийн агуулгын дэс дараагаар дараах 10 хэсэгт байрлуулжээ. Эдгээр нь:

Гол номлолд орох дөрвөн гишүүн (དབྱུང་བཤད་བལ་ལ་འཇུག་པའི་ཡན་ལག་བཞི།, 1-216)

Буяны садныг шүтэх ёсны үе (བཤེས་གཉེན་བརྟེན་ཚུལ་སྐབས།, 216-256)

Алгуур учралын үе (དལ་འབྱོར་གྱི་སྐབས།, 256-27a)

Үхэх мөнх бусын аймаг (འཆི་བ་མི་ཉག་པའི་སྐོར།, 27a- 34a)

Үйлийн үрийн аймаг (ལས་འབྲས་སྐོར།, 34a-37a)

Дунд төрөлхтний аймаг (སྐྱེས་བུ་འབྲིང་གི་སྐོར།, 37a-41a)

Их төрөлхтний үе (སྐྱེས་བུ་ཆེན་པོའི་སྐབས།, 41a-47a)

Амарлин ахуйн аймаг (ཞི་གནས་གྱི་སྐོར།, 47a-49b)

Налэндра хэмээх төвөд уламжлалт бичлэгийг Янжингавилодой санскрит бичлэгийн дагуу Наланда гэж зөв тодруулжээ. Мөн тус хийдийн түүхтэй холбоотой түүхэн үйл явдлыг дурдахын сацуу Наланда-гаас гадна Налэндра гэж хийд байсан гэж үзэж, тэдгээр нь хоорондоо байгуулагдсан газар орны тухайд ялгаатай гэжээ. Төвөдийн түүхч Даранатын (1575-1634) “Жанаг чойнжүн” буюу “Энэтхэгт бурханы шашин дэлгэрсэн түүх”-д Налэндра, Наланда гэж хоёр янзаар тэмдэглэснээс Налэндра гэсэн нь зонхилж байна (Ta ra na tha, 2022). Угтаа бол нэг хийдийн нэрийн хоёр өөр бичлэг бололтой.

Жишээ №2.

“Их бодь мөрийн зэрэг”-ийн дотроос өгүүлбэрийн утга санааг дэлгэрүүлж тайлсан нь:

“Цогт Налэндрагийн мэргэд багшийн хэл ариун, шавийн үндэс ариун, номлох ном ариун байх хэмээх гурван ариуны үүднээс ном номлохыг таалсан буй” хэмээн Зонховын бичсэнээс (Tsong kha ra, 2b) “багшийн хэл ариун” (སྐོར་དངོན་བྱི་བཀ་དག་པ།) гэдэг нь эс онож, эс ухсан, буруу оносон, эндүүрсэн зүйлгүй; “шавийн үндэс ариун” (སྐོར་མའི་རྒྱུད་དག་པ།) байх гэдэг нь мэргэн алдартан лугаа тэмцэх зай завсар эрэх, мөчөөрхөх сэтгэл, атаа тэргүүтнээр үндсээ эс гутаасан байх, “номлол ариун” (བཤམ་བྱུ་མའི་རྒྱུད་དག་པ།) байх гэдэг нь ном сургаалын уг ариун бөгөөд өгүүлэх утгын мөрт эс эндүүрсэн, тонилохыг хүсэгчдийн чухал хэрэгтэй бүхнийг анхааран авсан байх учиртай хэмээн тайлбарлажээ (Dbyang can dga' ba'i blo gros, 10b).

Жишээ №3.

Эх зохиолын зарим далд санааг тодруулж тайлбарласан нь:

“Бодь мөрийн зэрэг”-т “энэ увдис ер богд Майдарын “Илт онохуйн чимэг”-ийн увдис болно. Ялангуяа үүний гол сурвалж нь “Бодь мөрийн зул” мөн тул зохиогч нь үүний бас зохиогч болно. Тэр ч их багш Дивамгараширзняяна, бус нэрээр цогт Адиша хэмээн огоот алдаршжээ” (Tsong kha ra, 3a) гэсэн өгүүлбэр дэх **ЗОХИОГЧ НЬ ҮҮНИЙ БАС ЗОХИОГЧ БОЛНО** гэсэн хэллэгийг Янжингавилодой: “номлох ёсонд нийцтэй эс нийцтэй олон байх боловч өөрийн ёсыг товч хураангуйлбаас (санаагаа товч хэлбээс Д.Б) “Мөрийн зул”-ын зохиогч бол Адиша, энэ “Их бодь мөрийн зэрэг”-ийн өгүүлэгдэхүүн сайн зарлиг бүгдийн чухам утгыг гурван төрөлхтний мөрийн зэрэгт хурааж анхааран авах увдисын зохиогч ч мөн хэмээсэн утгатай. “Мөрийн зэрэг”-ийн увдисын уг нь ер “Илт онохуйн чимэг”-ийн увдис мөн бөгөөд ялангуяа “Илт онохуйн чимэг”-ийг гурван төрөлхтний мөрийн зэрэг лүгээ найруулж анхааран авах ёсны увдисын эх сурвалж бол “Мөрийн зул” мөн тул түүний зохиогч (Адиша Д.Б) нь мөрийн үес үүнд алимад номлохуй увдис үүний зохиогч мөн хэмээсэн утгатай” гэжээ (dbyang can dga' ba'i blo gros, 10b).

Өөрөөр хэлбэл, зохиогч нь үүний бас зохиогч болно гэж Зонховын бичсэнийг Янжингавилодой “Мөрийн зэрэг”-ийн зохиогч болох Адиша бээр “Илт онохуйн чимэг”-ийн увдис сургаалыг уламжилж авсан, тиймээс “Мөрийн зэрэг”-ийн зохиогч нь “Бодь мөрийн зэрэг”-ийн зохиогч гэж хэлсэн хэрэг хэмээн Янжингавилодой тайлбарласан

зүйчдээс Сумадираднаа “Харанхуйг арилгах зул” нэрт төвөд-монгол томоохон толь бичигтээ олон тайлбарыг товчлон найруулж оруулсан нь Янжингавилодойн бүтээл нь “Их бодь мөрийн зэрэг”-ийг уншиж судлахаас гадна толь бичиг найруулагчдад ч гэсэн чухал гарын авлага болж байсныг илтгэн харуулж байна.

3.2 Балман бандида Гончигжалцангийн дадол

“Их бодь мөрийн зэрэг”-ийн бас нэг дадол бол Балман бандида Гончигжалцангийн (1764-1853) зохиосон ལམ་རིམ་ཆེན་མོའི་བཅོམ་བུགས་སྟོན། (Ламрим чэнмой дадол шүгсо) гэсэн бүтээл болно. “Их бодь мөрийн зэрэг”-ийн ОХУ-ын Санкт-Петербург хотын Дорно дахины гар бичмэл номын хөмрөгт хадгалагдаж буй Lam rim chen mo'i brda chad shan sbyar ma bzhuḡs нэртэй төвөд- монгол толь бичигт (Сизова, 2014: 119-130) Гончигжалцангийн дадолыг ашигласан тухай А.А.Сизова дурджээ (2014: 125).

Гончигжалцангийн дадол “*лам хийгээд богд хамгийг айлдагчийн санд мөргөмүй. Мөрийн зэргийн зарим дохиог тайлах нь*” гэсэн хураангуй мөргөлийн үгтэй, оршил байхгүй, товч төгсгөлийн үгтэй. “Их бодь мөрийн зэрэг”-ийн бүлгийн дарааллыг жигд тэмдэглээгүй. Үг, хэллэгийн тайлбар нь хураангуй.

Жишээ №1.

Наландра (тө. ལྷ་ལེན།) гэсэн оноосон нэрийг “хулсны цэцэрлэг буюу хулсны дээр, үргэлжид дээш” (dkon mchog rgyal mtshan) гэж тайлбарлажээ. Үүнийг Янжингавилодойн (Жишээ №1) тайлбартай харьцуулна уу.

Жишээ №2.

ཟ་ཉླ་ гэсэн оноосон нэрийг санскрит хэлний Sa hor буюу ས་ཉླ་ гэсэн бичлэгийн гуйвуулсан хэлбэр гэжээ (dkon mchog rgyal mtshan, 1a). Янжингавилодой тус нэрийг Энэтхэгийн хааны язгуурын нэр гээд санскрит хэлний ས་ཉླ་ гэсэн нэрийн гуйвуулсан хэлбэр нь ཟ་ཉླ་ гэж бичжээ (12a).

Жишээ №3.

Адишагийн гарал үүслийн тухайд өгүүлсэн хэсэгт Адишагийн эцгийн орд харшийг Зонхов бээр “хятадын Донхун хаантай адил” баян тансаг гэж зүйрлэж бичсэн байдаг (Tsong kha pa, 3a-3b). Хятадын Донхун хаан гэснийг хэдэн янзаар тайлбарлаж ирснээс “Их бодь мөрийн зэрэг”-ийн хадмал тайлбар буюу чандэлд “Донхун” гэсэн нэрийн “дон” (ལྷོང་) бол мянга, “хүн” (ལྷན་)- янцаглах, аахилах гэсэн утгатай гээд энэ нэрийн утгыг “нэгэн хаанд гэдсэндээ дүүрэн гивантай заан байсан ба тэр бээр мянган заанд ийм гиван байсан бол ашиг олз ихтэй байж” гэх буюу “мянган хигээст хүрдний хигээсийн тоогоор хаан ном айлдаж, айлдах бүрдээ идээ зоог барьснаас” үүдэж энэ нэр гарсан гэжээ. Тодруулбал, хятадын хааныг их хүсэл шуналтай хаан гэснээс “Донхун” хэмээх нэр үүдэлтэй гэжээ (mchan 'grel, 5b). Харин Гончигжалцан “Донхун хааныг мянган заан ба мянган хигээст хүрдэт гэхчилэн номлосон байх боловч энэ нэр нь Донгүн (དོན་ལུན།) гэсэн

хятад үг бөгөөд хятадын хааны хотын нэр гэж Жанжаа Доржчан айлдсан” гэжээ (dkon mchog rgyal mtshan, 1a). Өөрөөр хэлбэл, Гончигжалцан бээр “Их бодь мөрийн зэрэг”-ийн чандэл буюу хадмал тайлбартай санал нийлээгүй байна. Мөнхүү Донхун гэсэн хятадын хааны нэрийг Янжингавилодой тайлбарлахдаа “Их бодь мөрийн зэрэг”-ийн хадмал тайлбар, Гончигжалцангийн мянган заан, мянган хигээст хүрдэт хаантай холбож тайлбарласныг дурдахын сацуу нэмж, Жанжаа Жамбагэлэгбалсан бээр айлдсаныг Ролбийдоржийн эшилснээс авчээ. Үүнд: тус хааны нэр хятад гаралтай гээд “дүн” (ᠳᠦᠨ) бол зүүн, “гүй” бол гүй гэсэн үг бөгөөд хаад түшмэдийг дуудах хятад үг, Хятадын зүүн зүгийн орны хаан гэж Жамбагэлэгбалсан бээр айлдсан гэжээ. Сумадираднаа бээр толиндоо ᠰᠤᠮᠳᠢᠷᠠᠳᠠᠨᠠᠭᠤᠨᠲᠤᠨᠳᠣᠤ гэсэн толгой үгийг оруулж, энэ үгийг хятад хэлний “зүүн орны хаан” болон “хотын хаан” гэсэн утгатай ᠰᠤᠮᠳᠢᠷᠠᠳᠠᠨᠠᠭᠤᠨ хэмээн Жанжаа Ролбийдоржийн тайлбарласныг авсан байна.

Тайлбаруудыг харьцуулбал, Гончигжалцан “Их бодь мөрийн зэрэг”-ийн тайлбарыг товчлон хураангуйлж, зарим шинэ санааг бусад сурвалжаас оруулжээ. Харин Янжингавилодойн тайлбар бол Гончигжалцангийнхаас илүү дэлгэрэнгүй, олон тайлбарыг нэгтгэсэн бөгөөд бас шинэ тайлбараар баяжуулсан байна. Гончигжалцан “Их бодь мөрийн зэрэг”-ээс 150 гаруй үг, хэллэгийг тайлсан, “Их бодь мөрийн зэрэг”-ийн хадмал тайлбарыг зонхилон үндэс болгосон, үгсийн сан, хэлний зүйн тайлбар голлосон байна.

4. Дүгнэлт

Янжингавилодой, Гончигжалцан нарын дадол буюу “дохионы тайлал”-д ижил төстэй тайлбар цөөн, нэг нь нөгөөгөө баяжуулсан болно. Янжингавилодой илүү олон үг хэллэг, нэр томьёо тайлбарласан, ашигласан сурвалж, аман мэдээгээр илүү дэлгэрэнгүй, Гончигжалцангийнх хураангуй. Энэ хоёр тайлбар төвөд, монгол толь зүйчдийн дунд их нэрд гарсан бөгөөд ялангуяа Янжингавилодойн тайлбарыг төвөд, монгол толь зүйч нар ашиглаж байсан нь Янжингавилодойн дадол нь төвөд хэл, утга зохиолыг судлах хүмүүст чухал дурсгал болохыг илтгэн харуулж байна.

Зонховын зохиосон “Их бодь мөрийн зэрэг”-ийн энэхүү хоёр дадол бол тус зохиолын дотор гарч буй зарим сонирхолтой болон ээдрээтэй бичлэгтэй үг хэллэг, нэр томьёо, санскрит болон хятад гаралтай оноосон нэр, хэлц хэллэг, домог тэргүүтнийг тайлбарласан, тус бүтээлийг судлах хүмүүст гарын авлага болох чухал хэрэглэгдэхүүн юм.

Ном зүй

Монгол хэлээр:

Монголын уран зохиолын тойм. (1977). Редактор Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд, Улаанбаатар. [Monggol un uran zokhiolyn toim, redactor, Ts.Damdinsüren, D.Tsend [Mongolian Literature]. Ulaanbaatar, 1977]

Мөнх-Отгон, Д. (2018). *Ц.Дамдинсүрэнгийн гэр музейн төвд ном судрын бүртгэл.*

редактор, Р.Отгонбаатар, А.Цендина, УБ., 870х. [Munkh-Otgon D, 2018. Ts.Damdinsurengiin ger muzein tuvud nom sudryn burtgel, redaktor, R.Otgonbaatar, A.Tsendina [Catalog of Tibetan Books Kept in the Damdinsuren House Museum]. Ulaanbaatar, Soyombo Printing. 2018]

Шагдарсүрэн, Ц. (2008). *Монгол толь бичгийн судлал, Толь бичиг судлалын асуудалд*, Улаанбаатар, х.19-68. [Shagdarsuren Ts, 2008. Mongol toli bichgiin sudlal, Toli bichig sudlaliin asuudald [Mongolian Dictionary Study: To the Study of the Lexicographic Problems]. Ulaanbaatar, Bembi San Printing. 2018]

Сацлал үгүй их Зонхавын зохиол их бодь мөрийн зэрэг оривой, буриад бар [Sačalal ügei yeke tsong khapa-yin jokiya yeke bodi mör-ün jerge orosibai]. Retrieved from <https://www.bdrc.io/>

Сумадиратна. (1959). *Төвөд монгол дохионы бичиг нэр утга гурвыг тодруулан харанхуйг арилгагч зул.* [Sumatiratna, *Bod hor kyī brda yig ming tshig don gsum gsal bar byed pa'i mun sel sgron me, Tübed mongyol un doqiyān-u bičig ner-e üge udqa ŋurban-i toduraŋulun qarāngqui yi arilŋaŋči jula*, Redigit prof. Dr. Rintchen, Ulaanbaatar. 1959]

Гадаад хэлээр:

dbyangs can dga' ba'i blo gros, Byang chub lam gyi rim pa chen po las byung ba'i brda bkrol nyer mkho bsdus pa bzhugs so, гар бичмэл, бүртгэлийн дугаар 958, Ц.Дамдинсүрэнгийн гэр музей.

dkon mchog rgyal mtshan, Lam rim chen mo'I brda bkrol bzhugs so, ҮНС, Ганданчойнхорлин хийдийн бар, дансны дугаар МОО43361.

btsan lha ngag dbang tshims, 1997. Brda dkrol gser gyi me long zhes bya ba bzhugs so, mi rigs dpe skrun khang, буриад бар. Retrieved from <https://www.bdrc.io/mnyam med tsong kha pa chen pos mdzad pa'i byang chub lam rim che ba bzhugs so>. Retrieved from <https://www.bdrc.io/>

ta ra na tha, 2022. Rgya gar chos 'byung dgos 'dod kun 'byung zhes bya ba bzhugs so. Retrieved from www.serajeyrigzodchenmo.rig

Сизова А.А., 2014. Тибето-монгольский словарь по терминологии “Ламрим ченмо” из коллекции ИВР РАН, Тибетология в Санкт-Петербурге, сборник статей, выпуск 1, Санкт-Петербург. [Sizova A.A, 2014. Tibeto-mongolskij slovar' po terminologii “Lamrim chenmo” iz kollekcii IVR RAN, Tibetologija v Sankt-Peterburge, sbornik statej, vpusk 1 Sankt-Peterburg.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>